

1

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САНХҮҮГИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ

Д.Дуламсүрэн, А.Энхбат

1. Макро эдийн засгийн санхүүгийн хөтөлбөрийн тухайд

Санхүүгийн хөтөлбөр зохиолт макро эдийн засгийн бодлого боловсруулах аргачлал юм. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн харилцан уялдаатай секторын тооцоонууд энэ хөтөлбөрийн гол үндэс болно. Иймээс макро эдийн засгийн хөгжлийг хангах бодлогын арга хэмжээний иж бүрэн цогц юм. Санхүүгийн хөтөлбөрийн төвд төлбөрийн балансын алдагдалт, өндөр инфляци, бүтээгдэхүүний бууралт буюу хэт бага өсөлтөөр илэрдэг нийт эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийн зөрчлийг арилгах зорилт оршдог. Түүнчлэн санхүүгийн хөтөлбөр нь нийт зарлага, орлого, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, үнэ, цалин, гадаад худалдаа, татварын орлого, улсын зардал, мөнгөний хэмжээ зэрэг эдийн засгийг бүхэлд нь хамарсан үзүүлэлтүүдийг судлах нэг арга хэрэгсэл болдог. Энэ нь практикт нэгдүгээрт дээрх нийтлэг үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг тайлбарлах, хоёрдугаарт эдийн засгийн өнөөгийн үйл явцын үр дагаврыг тооцоолж тодорхойлох, гуравдугаарт улс орны удирдлагыг эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэдээллээ хангаж өгөх гэсэн гурван гол зорилтыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Ийнхүү эдийн засгийг макро түвшинд судлахад дээрх нийтлэг үзүүлэлтүүдийг тооцоолж гол салбаруудын хоорондын уялдаа холбоог илрүүлж гаргах шаардлагатай бөгөөд санхүүгийн энэ хоёр зорилтыг хамтад нь шийдэж өгдөг.

Эдийн засгийн шинжээч, судлаач, бодлого боловсруулагчийн аль нь ч үндэсний

тооцоогүйгээр ажиллах аргагүй, яагаад гэвэл энэ бол:

- Эдийн засгийн байдал, төлөвийг шинжлэхэд гол үүрэгтэй хэмжигдэхүүнүүдийг системчлэх статистикийн араг яс.
- Эдийн засгийн өөрчлөлт хөгжлийг тодорхойлох хэмжүүр.
- Эдийн засгийн бодит байдлыг түүний хүрч чадах боломжтой харьцуулж харах арга.

“Санхүүгийн хөтөлбөр” гэж нэрлэдэг макро-эдийн засгийн бодлого боловсруулах аргачлалыг ОУВС-ийн шугамаар боловсруулж хэрэгжүүлдэг юм.

Макро эдийн засгийн тэнцвэр алдагдсан нөхцөлд **нөөц баялгийн одоогийн байгаа түвшин ба түүнийг шаардаж байгаа хэмжээний хоорондын зөрүүг арилгахын тулд эдийн засагт бодлогын өөрчлөлт, засвар зохицуулалт хийх шаардлагатай болдог**. Ийм зориудын бодлогын чанартай арга хэмжээг эртхэн авч хэрэгжүүлэхгүй бол аяндаа замбараагүй, үр ашиг муутай зохицолт хийгдэхэд хүргэдэг. Жишээлбэл, импортын зорилгоор гадаад валютын нөөцийг их зарцуулбал нөөц багасахад хүрч улмаар төлбөрийн тэнцлийг сайжруулах болоод бусад чиглэлээр орж ирэх гадаад эх үүсвэр хомсдох болно. Энэ нь импортыг эрс бууруулах, улмаар эдийн засгийн өсөлт, амьжиргааны түвшинд муугаар нөлөөлнө.

Санхүүгийн хөтөлбөрийн гол онцлог нь зохицуулах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх замаар гадаад санхүүжилтийг зохистой хэмжээгээр хангаж эдийн засгийн шаардлагатай өөрчлөлт зохицуулалтыг зохион байгуулалттай хийж гүйцэтгэхэд оршино. Санхүүгийн хөтөлбөрт дотоодын эрэлтийг хянаж төлбөрийн балансын тэнцвэр алдагдах байдлыг засахад мөнгө, төсөв болон валютын ханшны бодлогод голлон түшиглэдэг боловч бусад бодлого ялангуяа нийлүүлэлтийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг мөн тусгадаг. Ийм өөрчлөлт зохицуулалт нь үйлдвэрлэл буурч, ажилгүйдэл ихсэх үр дагаврыг зөөлрүүлж, эцсийн дүндээ цаашид тогтвортой байж чадахуйц төлбөрийн балансын дүнд хүргэх учиртай ажээ.

Төлбөрийн балансын тогтвортой байх дүн гэдгийг урсгал тооцоо, дунд хугацаанд яаж хөгжиж өөрчлөгдөх төлөв хандлагатай уялдуулан авч үзэх шаардлагатай. Улс орон бүр харилцан адилгүй боловч ерөнхийдөө урсгал тооцооны тогтвортой байж чадах дүн нь гаднаас орж ирж байгаа капиталын хэмжээ удаан хугацаагаар санхүүжүүлж хүрэхүйц бөгөөд тухайн орны гадаад өрөө төлөх чадвар болон эдийн засгийн өсөлт, үнийн тогтворжилтын зорилтыг хангахуйц түвшин гэж тодорхойлж болно.

Санхүүгийн хөтөлбөр нь ирээдүйд чиглэсэн агуулгатай байх нь мэдээж бөгөөд дунд хугацааг ойролцоогоор 5 жил гэж үзэж болох боловч бас яг тогтоосон гэж хатуу хэлж болохгүй юм. Харин иж бүрэн бодлого боловсруулах тулгамдсан шаардлага, мэдээллийн ойр бэлэн байдал зэргээс үүдэн ирэх оны санхүүгийн хөтөлбөр ямагт нарийвчилсан дэлгэрэнгүй хэлбэрээр хийгддэг ба дараа жилүүдийн хөтөлбөр арай товч, гол нь гадаад секторын өөрчлөлт зохицуулалтын үр дагаврын асуудалд төвлөрсөн байдаг.

2. Санхүүгийн хөтөлбөрийн хүрээ

Эдийн засгийн байдалд үнэлгээ өгч, өөрчлөлт зохицуулалтын бодлого боловсруулахад шаардагдах мэдээллийг үндэсний тооцоо, төлбөрийн баланс, төсвийн болон мөнгөний тооцоог хамарсан макро эдийн засгийн харилцан уялдаатай систем л бүрдүүлж өгдөг. Эдгээр тооцооны харилцан уялдаа нь аль нэг салбарын орлогоос давсан зарлагыг өөр нэг салбарын хэмнэлтээс санхүүжүүлэх ба нийт эдийн засгийн илүүдэл зарлагыг зөвхөн гадаад эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэдэг үнэнийг тод томруун харуулж өгдөг. Энэ бол хөгжиж байгаа, ядуу буурай орнуудад шууд холбоотой юм.

Бодлого боловсруулагчдын хувьд дээрх үзүүлэлтүүдийн системийн зэрэгцээ эдгээр нь бусад үзүүлэлтээс хэрхэн хамаарч өөрчлөгдөхийг харуулсан томъёоллын багц шаардагдана. Эдгээрийн оролцоотойгоор эдийн засгийн загварыг бүрдүүлэх бөгөөд түүний тусламжтайгаар инфляци, төлбөрийн баланс зэргийг хянаж удирдах бололцоотой үзүүлэлтүүдийг авч үзэж, үнэлгээ өгөх боломж бүрдэнэ. Иймээс аливаа бодлогын арга хэмжээний үр дагаврыг бүрэн тооцоолоход эдийн засгийн бүх секторыг зэрэг авч үзэх шаардлагатай нь ойлгомжтой юм.

Санхүүгийн хөтөлбөр боловсруулахад санхүүгийн үзүүлэлтүүд ба эдийн засгийн өсөлт, инфляци төлбөрийн баланс зэрэг эцсийн зорилт болох үзүүлэлтүүдийн хооронд тогтвортой хамаарал үйлчилж байгаа гэж үздэг боловч хэрэг дээрээ эдгээр хамаарлыг нарийн тогтоох нэн бэрхтэй бөгөөд орон тус бүрийн улс төр, бүтцийн болоод цаг хугацааны онцлогоос шалтгаалан өөр өөр байдаг. Ялангуяа бүтцийн гүнзгий өөрчлөлт, бодлогын шинэчлэл хийж байгаа нөхцөлд шинэчлэлийн буюу дараах үеийн харилцан хамаарал өмнөх үеийнхээс эрс өөрчлөгддөг тул эдийн засгийн дүн шинжилгээ хийж санхүүгийн хөтөлбөр боловсруулах ажлыг улам бэрхшээлтэй болгодог.

Мөн бодлого арга хэмжээнээс үр дүн гарах хугацаа, ирээдүйн талаарх хүмүүсийн төсөөлөл, итгэл үнэмшил, олон шалтгаант арга хэмжээний дотоод уялдаа зохицуулалт зэрэг нь ажлыг улам хүндрүүлж, эцсийн үр дүн яг ямар болохыг баттай тогтоох нь хэцүү юм.

3. Санхүүгийн хөтөлбөрийн бүтэц

Санхүүгийн хөтөлбөрт макро эдийн засгийн хүрээнд дэвшүүлж байгаа зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг багтаасан байна гэдгийг өмнө тэмдэглэсэн билээ. Иймээс санхүүгийн хөтөлбөр дараах бүтэцтэй байна.

- Бодит сектор
- Засгийн газрын сектор
- Мөнгөний сектор
- Гадаад сектор
- Уялдаа хамаарал

Санхүүгийн хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь бодит секторын тооцоо, төлөвлөлт, прогнозчлол байдаг. Иймээс энэ удаад санхүүгийн хөтөлбөрийн бодит

суурь болдог бодит секторын мэдээллийн багцыг авч үзсэн болно.

Бодит секторын тооцоо

Макро эдийн засгийн хүрээнд нийт зарлага, орлого үйлдвэрлэл, ажил эрхлэлт, үнэ цалин, гадаад худалдаа, татварын орлого, улсын зардал, мөнгөний хэмжээ зэрэг эдийн засгийг бүхэлд нь хамарсан үзүүлэлтүүдийг судалдаг. Практикт энэ нь дээрх нийтлэг үзүүлэлтийн өөрчлөлтийг тайлбарлах, эдийн засгийн өнөөгийн үйл явцын үр дагаврыг тооцоолж тодорхойлох, улс орны удирдлагыг эдийн засгийн бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг удирдамжаар хангаж өгөх гэсэн гурван гол зорилтыг шийдвэрлэхэд чиглэнэ.

Эдийн засгийн дүн шинжилгээ хийж, үйл явдлын учир шалтгааныг ойлгох, улмаар бодлого боловсруулахад юуны өмнө дээрх үзүүлэлтүүдийг хэмжих шаардлагатай. Макро эдийн засгийн гол хэмжигдэхүүнүүдийн талаарх мэдээллийг бүртгэж системчлэх арга нь үндэсний тооцоо юм. Үндэсний тооцооны хамгийн суурь ойлголт бол нийт бүтээгдэхүүн бөгөөд чөлөөт эдийн засгийн тогтолцоо бүхий орнуудад түүнийг Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ) буюу Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) гэж нэрлэдэг. Эдгээрийг тооцоолоход ҮНБ-ээс боловсруулсан Үндэсний тооцооны системийг (ҮТС) баримталдаг ба энэ аргачлалыг хамгийн сүүлд 1993 онд шинэчилсэн ажээ. ҮТС-нь тодорхой цаг хугацаанд тухайн эдийн засагт шинээр бий болгосон эцсийн бүтээгдэхүүнийг хэмжих бөгөөд түүнээс энэ орон юуг ямар хэмжээгээр, ямар салбарт үйлдвэрлэж орлого нь үйлдвэрлэлийн хүчин зүйлүүд, тухайлбал хөдөлмөр капиталд яаж ногдож байна гэдгийг харж болно.

Эдийн засгийн шинжээч, судлаач, бодлого боловсруулагчийн аль нь ч үндэсний тооцоогүйгээр ажиллах аргагүй юм.

- Эдийн засгийн байдал, төлөвийг шинжлэхэд гол үүрэгтэй хэмжигдэхүүнүүдийг системчлэх статистикийн араг яс.
- Эдийн засгийн өөрчлөлт хөгжлийг тодорхойлох хэмжүүр
- Эдийн засгийн бодит байдлыг түүний хүрч чадах боломжтой харьцуулж харах арга
- Янз бүрийн орны эдийн засгийг хооронд нь жишиж үзэх боломж юм.

Эдийн засгийг макро түвшинд судлахад дээрх нийтлэг үзүүлэлтүүдийг тооцоолж, гол салбаруудын хоорондын уялдаа холбоог илрүүлж гаргах шаардлагатай бөгөөд ҮТС энэ хоёр зорилтыг хамтад нь шийдэж өгдөг.

Төвлөрсөн төлөвлөлтийн орнуудад хэрэглэж байсан материаллаг бүтээгдэхүүний системд материаллаг цэвэр бүтээгдэхүүн гэдэг ойлголтыг суурь болгон авч үздэг ба энэ нь капиталын элэгдэл болон материаллаг бус үйлчилгээний салбарт бий болсон нэмүү өртгийг орхигдуулдагаараа ДНБ-ээс ялгаатай. Орон бүрийн зарим онцлог байдаг хэдийн боловч зарчмын хувьд материаллаг үйлчилгээнд зөвхөн үйлдвэрлэлийн “үргэлжлэл” гэж тооцогддог тээвэр хадгалалт, борлуулалтын холбогдолтой үйлчилгээг оруулдаг байв. Иймд эдгээр орны хувьд ДНБ материаллаг бүтээгдэхүүн дээр капиталын элэгдэл, материаллаг бус үйлчилгээг нэмж, материаллаг

бүтээгдэхүүнд давхар тооцогдсон материаллаг бус үйлчилгээний орцыг хасвал ДНБ гарах ёстой. Одоо ҮТС-д хэрэглэгддэг ангиллын чанартай зарим ойлголттой танилцъя.

Дотоодын ба үндэсний үзүүлэлтүүд: Гадаадын ба дотоодын бүтээгдэхүүн гэдэг нь улс орны нутаг дэвсгэрээр зааглагддаг ойлголт юм. ҮТС-д хоёр зарчмыг баримталдаг ба үүний нэг нь суурьшил, өөрөөр хэлбэл, тухайн хүн, үйлдвэрлэгчийн гол ашиг сонирхол төвлөрч байгаа буюу бусдаас илүү ойр нягт холбоотой орны зарчим юм. Жишээлбэл: Гадаадын компанийн хувьд эзэн нь гадаадынх байсан ч гол үйл ажиллагаагаа явуулж байгаа нутаг нь суурьшил болно. Хувь хүмүүсийн тухайд бол нэг жилээс дээш хугацаагаар оршин суугаа орон нь суурьшил гэж тооцогддог. Гэхдээ ЭСЯ зэрэг улсын байгууллагууд ямагт өөрийн оронд хамаарагддаг.

Нөгөө нэг зарчим нь өмчийн эрх бөгөөд тухайн оронд суурьшилтай эзэмшигчдийн өмчөөр бүтээсэн бүх бүтээгдэхүүн ҮНБ болдог. Энд тухайн орны иргэд биш, тухайн оронд оршин суугчид гэж ялгаж байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, тухайн оронд байгаа гадаадын компанийн бүтээгдэхүүн ҮНБ ба ДНБ-ийг аль алинд орох боловч гадаад дахь эздэд ногдох ашиг нь ҮНБ-ээс хасагддаг. Өөрөөр хэлбэл, ДНБ дээр тухайн оронд оршин суудаг өмчлөгчдийн гадаадад байгаа хөрөнгөөс орсон орлогыг нэмж, гадаадын өмчлөгчдөд ногдох орлогыг хасвал ҮНБ болно. Энэ зөрүүг үйлдвэрлэлийн хүчин зүйлийн гадаад цэвэр орлого гэдэг. Энд шууд хөрөнгө оруулалтын шинж чанартай орлого зонхилдог ба нэг жилээс бага хугацаагаар гадаадад ажиллаж байгаа хүмүүсийн гуйвуулсан орлого, газар, байрны түрээс зэрэг орлого багтана.

Урсгал ба түвшингийн үзүүлэлт: Нэг жилийн хугацаанд бүтээсэн ҮНБ зэрэг тодорхой хугацаанд болж өнгөрсөн үйл явдлыг хэмжсэн тооцоо бол урсгал чанартай үзүүлэлт юм. Тухайн үзүүлэлт цаг хугацааны нэгэн агшинд хүрээд байгаа түвшинг илэрхийлсэн тооцоо учраас урсгал үзүүлэлтээс ялгаатай. Түвшингийн болон урсгал үзүүлэлтүүд хоорондоо холбоотой. Жишээлбэл: жилийн туршид шинээр үйлдвэрлэгдсэн автомашины урсгал үзүүлэлт нь өмнөх жилийн эцэст байсан нийт машины түвшин дээр нэмэгдсэн хэмжээг харуулна. Үйлдвэрлэлийн барилга байгууламж болон тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгөөс элэгдлийг хасаж гаргасан цэвэр хөрөнгө оруулалтын урсгал үзүүлэлт нь хүний хөдөлмөрөөр бүтсэн капиталын нөөцийн цэвэр өсөлтийг харуулна. Эдийн засагчид ихэвчлэн урсгал үзүүлэлтүүдийг сонирхдог. Гэхдээ банкны системийн гадаад активийн цэвэр нөөц, гадаад болон дотоод өрийн үлдэгдэл, ажилгүйчүүдийн тоо зэрэг хэд хэдэн чухал түвшингийн үзүүлэлт эдийн засгийн судалгаанд ач холбогдолтой.

Нийтлэг үзүүлэлтийн цэвэр ба нийт дүн: Үндэсний тооцооны системд нийт бүтээгдэхүүн болон цэвэр бүтээгдэхүүнийг зааглаж үздэг. Нийт бүтээгдэхүүнийг тооцоходоо эцсийн бүтээгдэхүүн мөн эсэхийг үл харгалзан бүх үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний хэмжээг нэмж бодно. Жишээлбэл: үр тарианы аж ахуйнуудын үйлдвэрлэсэн тариа, гурилын үйлдвэрээс гарсан гурил болон талхны үйлдвэрийн талхны өртгийг нэмлээ гэвэл буудайн үнэ өртөг үйлдвэрлэлийн процесст гурван удаа тооцогдоно. Ингэж давхар тоолохгүйн тулд үндэсний орлогын тооцоонд зөвхөн эцсийн

№	Бодит сектор	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1	ДНБ (мянган төгрөгөөр)	283262	445500	598430	872082	946334	1069429	1183616	1261858	1400001	1554549
2	Бодит ДНБ-ий өсөлт (%)	2.3	6.3	2.4	4.0	3.5	3.2	1.1	1.1	3.7	5.0
3	ДНБ-ий дефляторын өсөлт (%), зарлагын дефляторын жинхэнэ дундаж	66.6	57.0	31.2	40.1	4.8	9.5	9.5	5.5	7.0	5.8
4	Хувийн хэрэглээ		56.9	46.7	36.9	11.2	7.6	9.4	5.1	6.5	5.2
5	Засгийн газрын хэрэглээ		56.9	46.7	36.9	11.2	7.6	9.4	5.1	7.9	7.3
6	Хөрөнгө оруулалт		31.9	31.9	42.2	7.2	17.3	8.7	5.3	6.5	5.3
7	Хөрөнгө оруулалт		29.9	5.2	46.8	-7.3	21.9	10.5	6.0	7.2	5.8
8	Бараа болон хүчин зүйлийн бус үйлчилгээний экспорт		19.6	28.4	43.0	4.5	22.0	9.9	5.4	6.6	5.3
9	Бараа болон хүчин зүйлийн бус үйлчилгээний импорт		605788	853063	927219	1068284	1207228	1317767	1476678	1652083	
10	ДНБ, зарлагын аргаар		373466	512000	592143	657535	722221	771028	852060	941572	
11	Хувийн хэрэглээ	51708	74143	96407	130727	155504	152199	175001	182604	198358	210009
12	Засгийн газрын хэрэглээ		147532	230000	262820	341280	363832	481894	591575	673424	
13	Хөрөнгө оруулалт ба үнэт цаасны өөрчлөлт		320130	440314	456372	551738	627709	675282	745566	828544	
14	Бараа болон хүчин зүйлийн бус үйлчилгээний экспорт		331747	-459978	-539620	-634467	-681534	-793042	-910880	-1001467	
15	Бараа болон хүчин зүйлийн бус үйлчилгээний импорт		-11617	-19664	-83248	-82730	-53825	-117760	-165314	-172923	
16	ДНБ-д эзлэх хувь		-1.2	2.2	2.0	2.0	0.1	-2.0	-4.4	-5.5	-6.3
17	Статистикийн зөрүү		-7357.9	19019.8	19114.4	1144.7	-23611.5	-55909.0	-76676.9	-97534.1	-6.3
18	(ДНБ-д эзлэх хувь)		-1.2	2.2	2.0	2.0	0	-2.0	-4.4	-5.5	-6.3
19	Хөрөнгө оруулалт / ДНБ-ий харьцаа		24.35	26.96	28.34	31.95	30.14	36.57	40.06	40.76	40.76
20	Харгалмаж / ДНБ-ий харьцаа		21.48	26.30	21.00	24.28	24.20	24.43	24.97	25.92	25.92
21	Харгалзаны үнийн индекс, жилийн эцэс (1995=100)	65.3	100	144.8	174.2	184.7	203.2	220.1	236.6	249.6	262.1
22	Харгалзаны үнийн индекс, жилийн дундаж	87.6	56.9	46.7	36.9	11.2	7.6	9.4	5.1	6.5	5.2
23	Өөрчлөлтийн хувь	52.7	82.7	121.3	166.0	184.6	198.6	217.3	228.3	243.1	255.8
24	Өөрчлөлтийн хувь	87.6	56.9	46.7	36.9	11.2	7.6	9.4	5.1	6.5	5.2
25	Өрх гэрийн сарын дундаж орлого (төгрөгөөр)	23861.0	35674.0	47099.0	65744.5	74938.8	82004.9	88726.5	93324.2	101641.8	110715.1
26	Өрх гэрийн сарын бодит орлого	23861.0	22733.0	20462.6	20871.9	21393.7	21757.4	21518.0	21539.6	22035.0	22806.2
27	% өөрчлөлт	41.0	-4.7	-10.0	2.0	2.5	1.7	-1.1	0.1	2.3	3.5
28	% өрх гэрийн сарын бодит орлогын өөрчлөлт (хүн амын өсөлттэй уялдан)	42.5	-3.2	-8.5	3.5	4.0	3.2	0.4	1.6	3.8	5.0
29	Өрх гэрийн сарын дундаж зарлага (төгрөгөөр)	23911.0	35206.0	46588.0	65031.2	74125.7	81115.2	87763.9	92311.7	100539.0	109513.9
30	Өрх гэрийн сарын бодит зарлага	23911.0	22434.8	20240.6	20645.4	21161.6	21521.3	21284.6	21305.9	21795.9	22558.8
31	% өөрчлөлт	39.0	-6.2	-9.8	2.0	2.5	1.7	-1.1	0.1	2.3	3.5
32	% өрх гэрийн сарын бодит зарлагын өөрчлөлт (хүн амын өсөлттэй уялдан)	40.5	-4.7	-8.3	3.5	4.0	3.2	0.4	1.6	3.8	5.0
33	Засгийн газрын бодит хэрэглээ	51708.3	47247.2	41884.9	41501.9	44393.6	40381.0	42441.3	42145.6	43002.0	43259.8
34	% өөрчлөлт	-8.6	-11.3	-0.9	7.0	-9.0	5.1	-0.7	2.0	2.0	0.6
35	Хөрөнгө оруулалтын бодит өсөлт (%)	26.2	21.9	6.4	6.6	10.7	-1.9	25.8	15.2	15.2	8.1
36	Хөрөнгө оруулалтын бодит өсөлт, (%)	79.4	-18.7	-21.4	7.8	-28.3	21.9	0.5	4.1	4.1	5.5
37	Хөрөнгө оруулалтын бодит өсөлт, (%)	22.5	63.7	1.6	1.8	20.3	-19.4	41.3	14.4	14.4	-1.9
38	Хувийн секторын хөрөнгө оруулалтын бодит өсөлт (%)	10	10	15	8.7	11.3	1.2	22	17	17	12.5

бүтээгдэхүүнийг нэмсний дараа “завсрын хэрэглээ” буюу бусад үйлдвэрүүдээс худалдан авсан бүтээгдэхүүнийг хасна. Энэ нь тухайн хугацаанд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг харуулна.

ҮТС-д дараах хоёр ойлголт нэр томъёог ашигладаг. Нэгд. ДНБ гэдэг нь элэгдлийг хасаагүй дүн. ДНБ-ий үзүүлэлтийг ашиглах нь гажуудалтай статистик хэрэглэхээс сэрэмжилдэг боловч бүх үйлдвэрлэлийн зориулалттай бараа давхар тооцогддог сул талтай. ҮТС-ийн хоёр дахь нийтлэг үзүүлэлт бол ДНБ-ээс элэгдлийн тооцож хассан дотоодын цэвэр бүтээгдэхүүн гардаг. Энэ үзүүлэлт давхар тооцоогүйгээр онолын хувьд давуу талтай боловч түүний нарийвчлал эргэлзээтэй байдаг. Үйлдвэржсэн өрнөдийн орнууд болон Дорнод Европын орнуудын аль алинд нь элэгдлийн хэмжээ ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцүү байна. Иймд практикт ДЦБ (ҮЦБ-ээс илүү ДНБ) ҮНБ-ний үзүүлэлтийг өргөн ашигладаг.

Ийнхүү ҮТС-д тооцогддог бусад эдийн засгийн үзүүлэлтүүдэд элэгдлийг оруулж тооцох эсэхээс хамааран нийт болон цэвэр гэсэн ялгааг өргөн хэрэглэдэг. Байна. Тухайлбал: тодорхой хугацаан дах элэгдлийн хэмжээгээрээ нийт болон цэвэр хөрөнгө оруулалт ялгагдана. Нийт хэмнэлт (gross saving) болон хэмнэлтийн (net saving) хооронд бас яг тийм ялгаа байдаг. Гэхдээ макро эдийн засгийн зарим бусад тооцоонд огт өөр утгаар хэрэглэгдэх явдал тохиолдоно. Үүнд: цэвэр импорт бол импорт экспортын зөрүү, гадаад цэвэр актив гэхээр гадаад активаас гадаад пассивийг хассан зөрүү гэж ойлгогдоно.

Нэрлэсэн ба бодит үзүүлэлтүүд: Тухайн үеийн үнээр тооцогдсон нийтлэг үзүүлэлтүүдийг нэрлэсэн, суурь үеийн зэрэгцүүлэх үнээр тооцсоныг бодит гэж нэрлэдэг. Тэгэхлээр тухайн жилийн нэрлэсэн ДНБ гэвэл уг оныхоо үнээр тооцогдсон эцсийн бараа, үйлчилгээний өртөг байна. Харин бодит ДНБ гэвэл яг ижил тоо хэмжээний бараа үйлчилгээг суурь оны үл хөдлөх үнээр үнэлж тооцсоныг хэлнэ. ДНБ-ий нэрлэсэн хэмжээ өөр өөр байх нь үнэ болон үйлдвэрлэлийн тоо хэмжээний өөрчлөлтийн аль нэгээс эсхүл хоёулангийнх нь өөрчлөлтөөс шалтгаалсан байж болно. Бодит ДНБ-ий өөрчлөлт зөвхөн эцсийн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамаарна.

Суурь онтой харьцуулахад үнийн дундаж түвшин хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлохдоо нэрлэсэн ДНБ-ийг түүний бодит хэмжигдэхүүнд харьцуулна. Уг харьцааг ДНБ-ий үнийн далд дефлятор гэж нэрлэдэг. Уг дефлятор нь суурь онд 1.0 буюу индекс хэлбэртэй бол 100 гэсэн утгатай байна. ДНБ-ий дефляторын дундаж түвшний нэг жилээс нөгөөд гарсан өөрчлөлт нь инфляцийн хамгийн өргөн хүрээтэй хэмжүүр болно.

Бодит секторын тооцооны аргачлалыг гүнзгий судалж, үзсэний үндсэн дээр өмнөх онуудын үзүүлэлтэд тулгуурлан санхүүгийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болох бодит секторын тооцоог 2003 оноор хийсэн болно.

2003 оны санхүүгийн хөтөлбөр боловсруулахдаа макро эдийн засгийн түвшинд бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг жил тутам 5-6 хувьд хүргэх, Монгол банкны гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, инфляцийн 12 сарын түвшинг нэг оронтой

тоонд байлгах зэрэг бодлогын зорилтуудыг тавьсаныг баримталсан.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд хангалттай гадаад санхүүжилт буюу гадаадын тусламж болон хөнгөлттэй зээлийг ашиглах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, төсвийн алдагдлыг багасгах, банкны зээлийн өсөлтийг хязгаарлах зэрэг арга хэрэгслүүдийг ашиглах зарчмуудад тулгуурласан.

Бодит секторын тооцоонд бодит ДНБ-ий өсөлтийг төгрөгөөр болон хувиар тооцсон бөгөөд зарлагын дефляторын өсөлтийг тооцож гаргасан. Нийт хэрэглээ буюу хувийн хэрэглээ Засгийн газрын хэрэглээ, хөрөнгө оруулалт, бараа болон хүчин зүйлийн бус үйлчилгээний импортыг мөн тооцсон болно.

Тухайлбал, ДНБ 2003 онд 1554.5 тэрбум буюу түүний зорилтод өсөлт 5 хувь байна. Үүнийг зарлагын дефляторын жигнэсэн дунджаар тооцвол 5.8 хувь болох тооцоо гарч байна. Хувийн хэрэглээ дефлятор хэрэглээний үнийн индекс (CPI)-ээр тооцооход 5.2 хувиар өсөх, засгийн газрын хэрэглээний хувьд бол дефлятор нь ХҮИ ба засгийн газрын цалингийн өөрчлөлтийн жигнэсэн дунджаар тооцоход 7.9%, хөрөнгө оруулалт нь валютын ханшны өөрчлөлт болон эрчим хүчний бус импортын барааны үнийн индексийн нийлбэрээр тооцооход 5.3 хувийн өсөлт гарах тооцоо байгаа юм.

Бараа үйлчилгээний нийт экспорт валютын ханшны өөрчлөлт, экспортын үнийн өөрчлөлтийн нийлбэрээр тооцож үзэхэд 5.8 хувь, бараа үйлчилгээний нийт импортыг валютын ханш болон импортын үнийн өөрчлөлтийн нийлбэрээр үзэхэд 5.3 хувь болж байна. Эдгээр үзүүлэлтийг өнгөрсөн жилүүдийн үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэлт хийхэд 2002 оны гүйцэтгэлээс бага зэрэг буурах 2001 оны түвшинд ойрхон очих байдал харагдаж байна. Гэтэл ДНБ 2001 оныхоос 2003 онд хэмжээний хувьд өссөн нь хүснэгтээс харагдаж байгаа, харин 2001 оны өсөлт 1.1 хувь байсан бол 2003 онд 5 хувь байх зорилт дэвшүүлсэн. Энэ үзүүлэлт бидний тооцоолсноор бага зэрэг өсөх хандлагатай байна.

2003 оны санхүүгийн хөтөлбөрийн бодит секторт хамаарагдах бусад үзүүлэлтүүдийг мөн тооцож хүснэгтээр харуулсан болно.